



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 5/20

Модот

Ш.Оюунчимэгт нэг удаагийн буцалтгүй
тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 243 дугаар тогтоол, 2024 оны 83 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хуульд заасан тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэнгийн албан тушаалаас чөлөөлөгдсөн Шаравын Оюунчимэгт албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн гурван жилээр тооцон 36 сарын цалинтай тэнцэх 26,915,690 (Хорин зургаан сая есөн зуун арван таван мянга зургаан зуун ерэн) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг Засаг даргын Тамгын газрын нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардлаас олгохыг Санхүү албаны Нягтлан бодогч (Б.Буяндэлгэр)-т зөвшөөрсүгэй.

2.Холбогдох хуульд заасны дагуу Ш.Оюунчимэгт олгох 26,915,690 (Хорин зургаан сая есөн зуун арван таван мянга зургаан зуун ерэн) төгрөг хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөгдөх болохыг дурдсугай.

ДАРГА



Ү.ИЧИНХОРЛОО